

**Golomt Capital<sup>®</sup>**

# ДЭЛХИЙН

---

**ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО  
ХОНОГИЙН ТОЙМ**

**2026.05.25**

## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ

### ТОВЧ

- АНУ-ын хувьцааны хөрөнгө оруулалтын багцаа хамгаалан TLT буюу 20 жилийн хугацаатай бондын ETF-д хөрөнгө оруулбал тохиромжтой.
- ОХУ-ын ерөнхийлөгчийн Хятадад айлчилсан шалтгаан гурван зүйл дээр тулгуурлав.
- Nvidia компанийн тайлан зарлагдсан. Хувьцааны ханшид 30%-ийн өсөлтийн боломж бий.
- АНУ-ын бондын өгөөж хүчтэй өссөөр байна.
- БНХАУ-ын технологийн компаниудын хувьцааны ханш савлагаатай хэвээр байна.
- АНУ-ын зах зээлд “earnings season” дуусаж уналтын хөдөлгөөн үүсэх боломжтой.



### S&P 500 индексийн 2026 оны таамаглал

Capital Economics	8,000
Deutsche Bank	8,000
Wells Fargo	7,800
Morgan Stanley	7,800
Goldman Sachs	7,750
RBC	7,750
JPMorgan	7,500
HSBC	7,500
UBS	7,500
Barclays	7,400
Bank of America	7,100
<b>Дундаж</b>	<b>7,645</b>



### iShares 20+ Year Treasury Bond ETF

NASDAQ: TLT

**84.68** USD ▲ +0.46 (+0.55%) today

SOFTWARE - INFRASTRUCTURE				SEMICONDUCTOR EQUIPMENT &			
<b>MSFT</b> -0.79%				<b>ORCL</b> -0.45%	<b>LRCX</b> +7.25%	<b>AMAT</b> -1.02%	<b>KLAC</b> +4.66%
<b>PLTR</b> +2.16%	<b>PANW</b> +7.31%	<b>UBER</b> -4.36%	<b>CRM</b> +5.78%	<b>TER</b> 0	<b>COMPTON</b> +0.49%	<b>ANET</b> +0.49%	<b>ANET</b> +0.49%
<b>CRWD</b> +2.66%	<b>FTNT</b> +9.08%	<b>INTU</b> +1.13%	<b>ADBE</b> +1.13%	<b>SNDR</b> +2.17%	<b>WDC</b> +0.47%	<b>STX</b> +0.47%	<b>WDC</b> +0.47%
<b>SNPS</b> +4.44%	<b>SNPS</b> +4.44%	<b>NOW</b> +0.99%	<b>ROBO</b> +0.99%	<b>STX</b> +0.47%	<b>WDC</b> +0.47%	<b>STX</b> +0.47%	<b>WDC</b> +0.47%



## АНУ-ын зах зээлийн онцлох мэдээ 2026.05.18-05.24

Долоо хоногийн эхэнд зах зээл хэлбэлзэлтэй байсан ч хиймэл оюун ухаантай холбоотой хувьцаануудын өсөлт хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээжээ. Ялангуяа Nvidia компанийн хүлээлтээс давсан санхүүгийн тайлан AI салбарын өөдрөг хандлагыг улам дэмжсэн бөгөөд энэ нь Ойрхи Дорнод дахь геополитикийн эрсдэлийн талаарх болгоомжлолыг тодорхой хэмжээнд сааруулсан байна.

### АНУ-ЫН БОНДЫН ҮНЭ БУУРЧ ӨГӨӨЖ ТҮҮХЭН ДЭЭД ХЭМЖЭЭНД ХҮРЛЭЭ

АНУ-ын 30 жилийн хугацаатай төрийн бондын өгөөж 5.19%-д хүрч, 2007 оны 7-р сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ. Энэ нь инфляц өсөх эрсдэлийн талаарх болгоомжлол нэмэгдэж байгаатай холбоотой юм. Төв банкууд зөвхөн валют хамгаалахаас гадна инфляц өсөх, бондын үнэ унах эрсдэлээс сэргийлэн хөрөнгийн бүтэцдээ өөрчлөлт хийж, илүү хөрвөх чадвартай бэлэн мөнгөн хөрөнгө рүү шилжиж эхэлжээ. Үүний нөлөөгөөр АНУ-ын төрийн бондын өгөөж өсөж, дэлхийн санхүүгийн зах зээлд дарамт нэмэгдэж байна.



TLT нь АНУ-ын 20 жилээс дээш хугацаатай Засгийн газрын бондуудад хөрөнгө оруулдаг ETF бөгөөд урт хугацааны хүүгийн хөдөлгөөнөөс хамгийн их ашиг хүртдэг сангуудын нэг юм. АНУ-ын хөрөнгийн зах зээлд магадгүй түр зуурын уналт орж ирж болох учраас найдвартай хөрөнгө болох TLT-д сул байгаа бэлэн мөнгөө хөрөнгө оруулбал тохиомжтой байна.

### NVIDIA КОМПАНИЙН ТАЙЛАН ЗАРЛАГДЛАА


Nvidia энэ улиралд дахин маш хүчтэй санхүүгийн үзүүлэлт тайлагнаж, орлого нь жилийн өмнөхөөс 85%-иар өсөж 81.6 тэрбум ам.долларт хүрлээ. Компани мөн 80 тэрбум ам.долларын хувьцаа буцаан худалдан авахаа зарлаж, ногдол ашгаа нэмэгдүүлсэн нь AI-ийн эрэлт асар өндөр хэвээр байгааг харуулж байна.

Гэсэн ч компанийн хамгийн том сорилтын нэг нь Хятад хэвээр байна. Тайлангийн дараах өгсөн ярилцлагадаа Jensen Huang АНУ-ын экспортын хатуу хязгаарлалтын улмаас Nvidia Хятадын AI чипийн зах зээлийг бараг бүхэлд нь Huawei-д “алдаад байна” гэж мэдэгдлээ. АНУ-ын экспортын хориг нь Хятадын технологийн бие даасан байдлыг улам хурдасгаж, Huawei-г AI чипийн зах зээлд Nvidia-ийн хамгийн том өрсөлдөгчдийн нэг болгож байна.



**АНУ-ын хувьцааны техник шинжилгээ 2026.05.18-05.24**

**NYSE: NVDA 30%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ - ЗОРИЛТ: 255\$**



Өнгөрсөн лхагва гарагт тайлан танилцуулагдаж, хүлээлтээс сайн гарсан ч хувьцааны ханш унасан. Гэвч дунд хугацаандаа өсөлт үргэлжлэх төлөвтэй байгаа бөгөөд 200\$ болон 210\$ орчим түвшин дээрээс худалдан авалтыг хийвэл тохиромжтой.

**NYSE: MSFT 20%-ИЙН ӨСӨЛТИЙН БОЛОМЖ БИЙ - ЗОРИЛТ: 485\$**





## Хөрөнгийн зах зээлийн онцлох мэдээ 2026.05.18–05.24

Хятадын хөрөнгийн зах зээл өнгөрсөн долоо хоногт буурсан үзүүлэлттэй байлаа. Учир нь 4-р сарын эдийн засгийн идэвхжил хүлээлтээс сул гарч, эдийн засгийн өсөлтийн төлөвт дахин эргэлзээ үүсгэсэн байна. Ялангуяа технологийн компаниуд болон экспортод түшиглэсэн салбарууд дэлхийн бондын өгөөж өссөн, мөн гадаадын хөрөнгө оруулагчдын эрсдэлтэй хөрөнгө оруулалтад хандах сонирхол буурсны улмаас савлагаатай арилжаалагдаж байна.

### ОХУ-ЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЙЛЧЛАЛ ГУРВАН ЗҮЙЛ ДЭЭР ТУЛГУУРЛАВ

ОХУ-ын Ерөнхийлөгч Vladimir Putin БНХАУ-д айлчилж байгаа нь зөвхөн харилцаагаа бататгах бус, худалдаа, эрчим хүч болон геополитикийн чиглэлээр тодорхой ашиг хүртэх зорилготой гэж үзэж байна.

1. ОХУ Хятадын геополитикийн дэмжлэгийг хадгалахыг зорьж байна. Putin Хятадтай ойр холбоотой хэвээр гэдгээ АНУ болон өрнөдийн орнуудад харуулахыг хүсэж байгаа бөгөөд Украины дайны асуудал дээр Бээжингээс дипломат дэмжлэг авах сонирхолтой байна. ОХУ баруун талдаа НАТО болон Украины дарамттай байгаа учраас зүүн талдаа Хятадтай бат бөх холбоо тогтоох нь стратегийн ач холбогдолтой гэж үзэж байна.
2. Эрчим хүчний хамтын ажиллагаа хамгийн чухал асуудлуудын нэг хэвээр байна. ОХУ Европын зах зээлээ алдсанаас хойш Хятад руу газрын хий, нефтийн экспортоо нэмэгдүүлэхээс ихээхэн хамаарах болсон. Ялангуяа Монголоор дамжин Хятад руу хүрэх "Power of Siberia 2" хийн хоолойн төслийг урагшлуулахыг Putin хүсэж байгаа ч Хятад энэ асуудалд яарахгүй байгаа аж. Учир нь БНХАУ эрчим хүчний эх үүсвэрээ төрөлжүүлж, хангалттай нөөц бүрдүүлсэн гэж шинжээчид тайлбарлаж байна.
3. ОХУ Хятадаас технологи, үйлдвэрлэлийн бараа болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүний хамаарлаа улам нэмэгдүүлж байна. Украины дайнаас өмнө Европ ОХУ-ын хамгийн том худалдааны түнш байсан бол одоо Хятад тэр байр суурийг эзэлж, хоёр улсын худалдааны хэмжээ сүүлийн дөрвөн жилд хоёр дахин өссөн байна. Иймээс Москва Бээжинтэй эдийн засгийн хамтын ажиллагаагаа аль болох олон салбарт өргөжүүлэхийг зорьж байгаа юм.

Hang Seng индекс



**Хүснэгт 1: Өнгөрсөн долоо хоногт тайлангаа зарласан компаниуд**

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
May 18, 2026									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
BIDU <b>Baidu</b>	AGYS <b>agilysys</b>	HD <b>Home Depot</b>	KEYS <b>KEYSIGHT TECHNOLOGIES</b>	ADI <b>ANALOG DEVICES</b>	NVDA <b>NVIDIA</b>	NIO <b>NIO</b>	DECK <b>DECKERS BRANDS</b>	BAH Boaz   Allen   Hamilton	
TOYO <b>TOYO SOLAR</b>	FATP <b>FAT Pipe</b>	VRTV <b>VERTIV</b>	CAVA <b>CAVA</b>	VFC <b>VFC CORPORATION</b>	ELF <b>elf.</b>	WMT <b>Walmart</b>	BULL <b>Webull</b>	BJ <b>BJ's</b>	
NRXP <b>NRx</b>	GSSS <b>gossamerbio</b>	AS <b>AMER SPORTS</b>	TOL <b>Toll Brothers</b>	ZM <b>ZIM</b>	INTU <b>intuit</b>	DE <b>JOHN DEERE</b>	ZM <b>zoom</b>	GSL GLOBAL SHIP LEASE	
BRC <b>BRADY</b>		ECC <b>EAGLE POINT</b>	AUNA <b>aluna</b>	TGT <b>TARGET</b>	SELK <b>STAR BULK</b>	ADS <b>ADS</b>	WDAY <b>workday</b>		
CGEN <b>compugen</b>		MYFY <b>make my trip</b>	CCF <b>CARLYLE</b>	LOW <b>LOWE'S</b>	URBN <b>URBAN OUTFITTERS</b>	LSPD <b>lightspeed</b>	TWO <b>12</b>		
RNW <b>ReNew POWER</b>		RENE <b>万物新生 A I RENEW</b>	RRGB <b>Red Robin</b>	ARC <b>Arco Dorados</b>	STEP <b>STEPSTONE</b>	HLNE <b>Hamilton Lane</b>	COPT <b>Copart</b>		
IQI <b>爱奇艺</b>		RDCM <b>RADCOM</b>	JHXX <b>James Hardie</b>	HAS <b>Hasbro</b>	NDSN <b>Nordson</b>	AAP <b>Advance! Auto Parts</b>	FLO <b>Flowers</b>		
DUOT <b>duostech</b>		LUXE <b>LuxExperience</b>	ZTO <b>ZTO 中通快递</b>	GDS <b>万国数据</b>	BLTE <b>Belite BIO</b>	DAVA <b>endava</b>	ROST <b>ROSS DRESS FOR LESS</b>		
		HSAI <b>HESAI</b>	XCEL <b>XCEL BRANDS</b>	TJX <b>TJX</b>	ENS <b>EnerSys</b>	RALP <b>RALPH LAUREN</b>	RAMI <b>LiveRamp</b>		
		CRNT <b>CERAGON</b>	EGHT <b>8x8</b>	PERI <b>Perion</b>		NTES <b>NetEase Games</b>	LION <b>LIONSGATE</b>		

http://eps.sh/cal

© 2026 Earnings Whispers

**Хүснэгт 2: Энэ долоо хоногт тайлангаа зарлах компаниуд**

E EARNINGS WHISPERS									
Most Anticipated Earnings Releases									
for the week beginning									
May 25, 2026									
Monday		Tuesday		Wednesday		Thursday		Friday	
Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	After Close	Before Open	
	JOYY <b>Joyy</b>	ESLT <b>Elbit Systems</b>	ZS <b>zscaler</b>	DKS <b>DICK'S SPORTING GOODS</b>	MRVL <b>MARVELL</b>	BBY <b>BEST BUY</b>	DELL <b>DELL</b>	ELMT <b>THE ELMET GROUP</b>	
		AZO <b>ArcoZone</b>	SQM <b>SQM</b>	POD <b>拼多多</b>	CRM <b>salesforce</b>	PLBI <b>PHOTRONICS</b>	PATH <b>UiPath</b>	FUFU <b>BitFuFu</b>	
		PONY <b>pony .ai</b>	BOX <b>box</b>	ANF <b>Abercrombie &amp; Fitch</b>	SNOW <b>snowflake</b>	HRL <b>Hormel Foods</b>	MDB <b>mongoDB</b>	KNOP <b>KNOT Offshore Partners LP</b>	
		CRGO <b>FREIGHTOS</b>	MOD <b>MODINE</b>	BNS <b>Scotiabank</b>	SNPS <b>SYNOPSIS</b>	XPEV <b>X P ENG</b>	CDST <b>COSTCO WHOLESALE</b>		
		SKY <b>CHAMPION HOMES</b>	SMTG <b>SEMTECH</b>	CPRI <b>CAPRI HOLDINGS LIMITED</b>	P <b>Everpure</b>	CM <b>CIBC</b>	ADSK <b>AUTODESK</b>		
		VNET <b>世纪互联 VNET</b>	API <b>agora</b>	BEBI <b>Bath &amp; Body Works</b>	HPQ <b>hp</b>	ARBE <b>arbe</b>	LS <b>SentinelOne</b>		
		CSW <b>CSW INDUSTRIALS</b>	APPS <b>digital turbine</b>	BMO <b>BMO</b>	NCNO <b>ncino</b>	KSS <b>KOHL'S</b>	ESTC <b>elastic</b>		
			ODMA <b>Ooma</b>	DY <b>DYCOM</b>	AMSC <b>amsc</b>	BURL <b>Burlington</b>	OKTA <b>okta</b>		
			QFIN <b>QIFU 奇富科技</b>	MWDI <b>MediWound</b>	BRZE <b>braze</b>	WB <b>新浪微博 weibo.com</b>	NETA <b>NetApp</b>		
			SVM <b>SILVERCORP METALS INC.</b>	MLAB <b>MesaLabs</b>	A <b>Agilent Technologies</b>	RY <b>RBC</b>	ASAN <b>asana</b>		

http://eps.sh/cal

© 2026 Earnings Whispers